



**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**



## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан.....	3
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл: .....	8
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар .....	9
2.8.3	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	11
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	12
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	12
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	12
3	Менежментийн захидал.....	13
3.1	Зардлын данстай холбоотой асуудал .....	13
3.2	Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал .....	14
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	15
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	16
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	18
4.5	Аудит хийсэн жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА Б.БААСАНДОРЖ  
ТАНАА

2019.03.25 № 01/579  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Аудитын гол асуудал

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төсвийг зүй зохистой удирдаагүйгээс авлага үүсгэсэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, төсвийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг нийт 488.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тооцсон материаллаг байдлын түвшингээс давж, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## Үүрэг хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ



## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Баасандорж Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 3 дугаар сарын 12-ноос 2019 оны 3 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ҮАГ-ын Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Эрдэнэзул хийж гүйцэтгэв.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг ҮАГ-ын Санхүүгийн аудитын газарт 2019 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 1/1800 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.





### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 16 дугаар зүйлд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авах;
- бүх шатны бүртгэлийн байгууллага, улсын бүртгэгчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах;
- улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн цаасан болон цахим архив, цахим мэдээллийн санг үүсгэх, хөтлөх, төрөлжүүлэн хадгалах, тэдгээрийн хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах;
- улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар гадаад улс, олон улсын бүртгэлийн болон төрөлжсөн бусад байгууллагатай Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллах;
- Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, тэдгээрийн харьяа байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх;
- салбарын хэмжээний мэргэжлийн боловсон хүчний чадавх, техник технологи, программ хангамжийн хүчин чадлыг сайжруулах асуудлыг нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх;



- улсын бүртгэлийн хөтлөлт, эх нотлох баримтын үнэн зөвийг нягтлан бүрдлийг хангах, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах замаар улсын бүртгэлийн үнэн зөв, бодит байдлыг хангах;
- улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаарх мэдээ, тайланг улсын хэмжээнд нэгтгэн гаргах, хуульд заасны дагуу мэдээлэх;
- улсын бүртгэгчийг бэлтгэх, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах;
- улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх баримт бичгийн загвар, маягт, холбогдох заавар, журмыг хуульд заасны дагуу баталж мөрдүүлэх;
- улсын бүртгэлийн аргачлал, арга зүйг олон улсын ангилал, стандартын жишигт нийцүүлэн боловсруулж, эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр гаргаж мөрдүүлэх;
- хууль тогтоомжид заасан бусад.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Улсын бүртгэлийн багц хуулиуд
- Холбогдох бусад тогтоол, шийдвэрүүд.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв. Үүнд:

- УИХ-ын 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн чуулганы хуралдаанаар Улсын бүртгэлийн багц хууль /Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай/-ийн шинэчилсэн найруулгын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж баталсан бөгөөд 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хуулийг мөрдөн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Засгийн газрын 2018 оны Засгийн газрын агентлагийн талаар авах арга хэмжээний тухай 175 дугаар тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрыг татан буулгаж, “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Улсын бүртгэлийн ерөнхий газар”, “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Оюуны өмчийн газар”-ыг тус тус байгуулсан байна.
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/131 дүгээр тушаалаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн баталжээ.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг



алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дотоод аудитын алба тайлант хугацаанд Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаанд 4 дүгээр сард хяналт шалгалт хийж, цаашид 4 асуудлыг анхааруулж, 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Улсын бүртгэлийн ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт орлогыг сонгов.

Энэ нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Нийт хөрөнгө, цэвэр хөрөнгийн дүн өндөр, нийт зардлын дүн бага тул нийт орлогыг суурь үзүүлэлт болгон сонгосон.





Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2018 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн *нийт орлого 28,420.9* сая төгрөгийн 1 хувь буюу 284.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлээр төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтээс 1 хувиар тооцсон нь төлөвлөлтийн үе шатанд эрсдэлийг дунд гэж үнэлсэнтэй холбоотой юм.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 23 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 18 байгууллага аудитад хамрагдсан байна.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагд аагүй
1	Төсвийн шууд захирагч	18	2	3	0
	<b>Дүн</b>	<b>18</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>0</b>

Аудитад хамрагдсан 18 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт гарсан байна.

### 2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 3,449.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 84.6 хувь буюу 2,917.1 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 0.1 хувь буюу 5.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 14.3 хувь буюу 493.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 1 хувь буюу 33.8 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 2,735.9 сая төгрөгийн, төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд 181.2 сая төгрөгийн алдааг залруулсан болно.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.



(сая төгрөг)

№	Байгууллагын ангилал	Залруулагуй алдаа, зөрчил		Үүнээс:									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	31	531.9	6	5.0	9	493.1	16	33.8				
	<b>Дүн</b>	<b>31</b>	<b>531.9</b>	<b>6</b>	<b>5.0</b>	<b>9</b>	<b>493.1</b>	<b>16</b>	<b>33.8</b>				

### 2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Улсын бүртгэлийн ерөнхий газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүрээний 18 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргаснаас материаллаг хэмжээний, анхаарал татахуйц алдаа, зөрчил илрээгүй байна. Аудитын дүнд нийт 43.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 5.0 сая төгрөгийн зөрчлийг нөхөн төлүүлэх 6 төлбөрийн акт, 4.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 6 албан шаардлага, 33.8 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх 14 зөвлөмж хүргүүлсэн байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамруулан үзсэнээр нийт 488.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 3 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлээ.

### 2.8.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитаар илрүүлсэн залруулагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Улсын бүртгэлийн ерөнхий газарт зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд тусгаж, бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### Асуудал 1: Худалдан авах ажиллагаа

Тайлант хугацаанд 5 удаагийн 204.5 сая төгрөгийн худалдан авалтад холбогдох хууль, журмыг мөрдөөгүй байна.



Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийг тус тус зөрчсөн байна.

#### **Шийдэл:**

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

#### **Асуудал 2: Төсвийн гүйцэтгэл**

Зохих зөвшөөрлийг авалгүйгээр 99.5 сая төгрөгийн зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын 5.4 “Төсвийн байгууллага нь зардлын бүлгийн дүнд багтаан эдийн засгийн ангиллын дагуу зардал гаргах бөгөөд хугацаа хэтэрсэн өр, төлбөр, үүсгэхгүйгээр хөтөлбөр, арга хэмжээний зорилтыг бүрэн хангахаар төсвийг зохицуулна.”, 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

#### **Шийдэл:**

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

#### **Асуудал 3: Авлага**

Он дамжсан насжилт ихтэй авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй 52.8 сая төгрөгийн, урсгал үйл ажиллагааны зардлаас хэрэгжүүлж буй бараа ажил, үйлчилгээний төлбөрийг урьдчилан шилжүүлж 131.5 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

#### **Шийдэл:**

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.



## 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан дараагийн аудитаар нарийвчлан авч үзэх дараах асуудлууд байна. Үүнд:

1. Хөрөнгө, бараа материалыг бодит хэрэгцээнд үндэслэн төлөвлөж, бэлтгэдэг эсэх, ашиглалт, хадгалалт үр дүнтэй байгаа эсэх;
2. Иргэний бүртгэлийн цахим лавлагааны төхөөрөмжүүдийн ашиглалт, хадгалалт, орлого бүрдүүлэлт, төвлөрүүлэлтэд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлнэ.

Аудитын явцад анхаарал татахуйц, төсвийн дээд шатны төсвийн захирагчийн анхааралд хандуулах шаардлагатай дараах асуудлууд ажиглагдлаа. Үүнд:

1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018.12.14-ний өдрийн тушаалаар "Давсан болон нэмэлт орлогыг зарцуулах эх үүсвэрээс худалдан авалт хийх арга хэмжээний жагсаалт"-ыг баталснаас шалтгаалан худалдан авах ажиллагааг богино хугацаанд зохион байгуулж, хөрөнгийг урьдчилан бүрэн шилжүүлэхээр гэрээ хийн, гэрээний дагуу төлбөрийг шилжүүлж нийт 410.3 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна.
2. Төрийн байгууллагуудыг татан буулгах, шинэчлэн байгуулахад санхүүгийн тайланд бүртгэлтэй Засгийн газрын оруулсан капитал дансыг хэрхэн шийдвэрлэх заавар, чиглэл байдаггүйгээс Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрыг татан буулгаж, Оюуны өмчийн газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрыг байгуулахдаа Засгийн газрын оруулсан капитал данс дахь 11,471.2 сая төгрөгийг хэрхэн шийдвэрлэх талаар шийдвэр гараагүй байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Улсын бүртгэлийн ерөнхий газарт 2 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан улсын төсвийн санхүүжилтээр 27,184.1 сая төгрөгийн төсвийг зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Улсын төсвөөс 23,764.1 сая төгрөгийн урсгал, 3,420.0 сая төгрөгийн хөрөнгийн санхүүжилт олгохоор батлагдаж, урсгал санхүүжилт бүрэн, хөрөнгийн санхүүжилт 127.2 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

Зардлын нийт гүйцэтгэл 26,992.1 сая төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь хөрөнгийн санхүүжилт дутуу санхүүжигдэж, гүйцэтгэл дутуу гарсантай холбоотой байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын хүрээний байгууллагуудын нэмэлт санхүүжилтээр нийт 1,071.6 сая төгрөгийн санхүүжилт төвлөрч, 1,070.9 сая төгрөгийг зарцуулан 4.3 сая төгрөгийн үлдэгдлийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.



## 2.11. Шилэн дансны мэдээлэл

Улсын бүртгэлийн ерөнхий газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус газрын дотоод аудитын албанаас сар бүр Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянажээ. Жилийн эцсийн байдлаар нийт 23 төсвийн шууд захирагчийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 95.1 хувьтай байгаа бөгөөд мэдээлбэл зохих 3427 мэдээллийг бүрэн байршуулсан ч улирал бүр илгээх 92 тайланг 90.2 хувьтай илгээсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 9 зөвлөмж өгснөөс 6 зөвлөмжийг хэрэгжүүлж, 3 зөвлөмж хэрэгжээгүй буюу нийт 66.7 хувийн биелэлттэй байна.

Дараах зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Үүнд:

- Олон жил болсон авлага, өглөгийг барагдуулах талаарх тодорхой арга хэмжээ авч ажиллах,
- Төсвийн хэмнэлтээс зарим зардлыг урьдчилан шилжүүлж авлага нэмэгдүүлэхгүй байх,
- Дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах /цалингийн сангаас нэг удаагийн тэтгэмж урамшуулал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд зарцуулсан зөрчил давтагдан гарсан/.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## 2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргасныг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.





## 2 Менежментийн захидал

